



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур Гэрэлтүүлэг Чимэглэл ААТҮГ-ын 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/075/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд
Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 325093 Цахим хаяг: altantsetesegya@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит
ХХК-ийн захирал Д.Баатарсайхан

Утас: 99099119 Цахим хаяг: info@ghtaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54

И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Баян. 03.14

№ 01/284

танай _____-ны № _____-т

БАГАНУУР ГЭРЭЛТҮҮЛЭГ
ЧИМЭГЛЭЛ ААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.БАТНАСАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Багануур Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 17.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/623 дугаар тушаалаар 61.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Багануур дүүргийн Засаг даргын тамгын газарт, Багануур дүүргийн Засаг даргын 2024 оны А/411 дүгээр захирамжаар 42.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг Боршоон-Ундраа ХХК, Телекамерын хяналтын дэд төвд тус тус шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Багануур дүүргийн ИТХ-ын 2023 оны 28 тоот тогтоолоор Багануур Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ыг татан буулгах ажлын хэсэг байгуулагдсан, дээрх тогтоолын 5 дахь хэсэгт "... үйл ажиллагааг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр

гүйцэтгүүлсэн өдрөөс эхлэн үүсгэн байгуулсан тогтоолыг хүчингүйд тооцсугай” гэж заасны дагуу 2024 оны 9 дүгээр сараас үйл ажиллагаа, санхүүжилт зогссон байна.

Бусад асуудлын хэсэг

Багануур дүүргийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 4 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлээр 88.5 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГА

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,854,339.54	0.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	2,077,919.01	0.00
1.1.06	Бараа материал	79,197,070.44	0.00
1.1.07	Урьдчилж төлсөн зардал	100,977.04	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	88,230,306.03	0.00
1.2.01	Үндсэн хөрөнгө	94,233,653.88	46,475,000.19
1.2.02	Биет бус хөрөнгө	1,365,000.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	95,598,653.88	46,475,000.19
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	183,828,959.91	46,475,000.19
2.1.1.01	Дансны өглөг	511,827.86	0.00
2.1.1.03	Татварын өр	7,275,769.50	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,787,597.36	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,787,597.36	0.00
2.3.01	Өмч: - төрийн	165,216,667.00	185,216,667.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,000,000.00	6,000,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	4,824,695.55	144,741,666.81
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	4,824,695.55	4,824,695.55
2.3.11	Эздийн өмчийн дүн	176,041,362.55	46,475,000.19
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	183,828,959.91	46,475,000.19

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	953,309,090.92	700,580,474.95
02	Борлуулалтын өртөг	896,677,321.90	555,205,903.03
03	Нийт ашиг(алдагдал)	56,631,768.99	145,374,571.92
08	Бусад орлого	79,302,935.23	8,930,030.85
08.1	Орлогын дүн	79,302,935.23	8,930,030.85
10	Ерөнхий ба удирдлагын зардал	183,207,274.84	303,870,965.13
12.1	Зардлын дүн	183,207,274.84	303,870,965.13
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-47,220,532.06	-149,566,362.36
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-47,220,532.06	-149,566,362.36
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-47,220,532.06	-149,566,362.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Багануур Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,137,244,135.88	774,414,103.52
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,048,640,000.00	754,442,474.94
1.1.6	Бусад мөнгөн орлого	88,604,135.88	19,971,628.58
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,170,574,574.47	780,301,543.06
1.2.1	Ажиллагчдад төлсөн	286,997,212.00	215,000,187.26
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	92,885,505.76	62,463,321.74
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	336,190,108.00	165,629,470.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	250,124,511.34	180,450,393.86
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	55,919,260.00	36,114,620.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	67,217,895.68	52,566,385.05
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	870,690.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	80,369,391.69	68,077,165.15
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	33,330,438.59	5,887,439.54
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,289,900.00	966,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,289,900.00	966,900.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,289,900.00	966,900.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	39,620,338.59	6,854,339.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	46,474,678.13	6,854,339.54
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,854,339.54	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	165,216,667.00	6,000,000.00	4,824,695.55	176,041,362.55
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				0.00
Залруулсан үлдэгдэл	165,216,667.00	6,000,000.00	4,824,695.55	176,041,362.55
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-149,566,362.36	-
Бусад дэлгэрэнгүй орлого				0.00
Өмчид гарсан өөрчлөлт	20,000,000.00			20,000,000.00
Зарласан ногдол ашиг				0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				0.00
2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	185,216,667.00	6,000,000.00	-144,741,666.81	46,475,000.19

Багануур Гэрэлтүүлэг чимэглэл ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2023 он	2024 он		Зөрүү	Хувь
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
А.Үндсэн үйл ажиллагааны орлого						
1	Санхүүжилтийн орлого	1,048,640.0	1,152,453.2	700,580.5	451,872.7	60.8
2	Бусад орлого	88,604.1	25,000.0	8,930.0	16,070.0	35.7
	Нийт орлогын дүн	1,137,244.1	1,177,453.2	709,510.5	467,942.7	60.3
Б.Үндсэн үйл ажиллагааны зардал						
1	Цалин	286,997.2	327,061.3	215,000.2	112,061.1	65.7
2	Урамшуулал	50,341.5	71,650.0	-	71,650.0	-
3	НДШ	51,576.3	58,752.0	62,463.3	(3,711.3)	106.3
4	Ашиглалтын зардал	250,124.5	278,206.9	180,450.4	97,756.5	64.9
5	Түрээсийн зардал	19,279.6	15,000.0	1,595.8	13,404.2	10.6
6	Албан томилолт	1,610.0	1,850.0	-	1,850.0	-
7	Элэгдлийн зардал	44,242.3	45,000.0	27,234.8	17,765.2	60.5
8	Хөдөлмөр хамгааллын зардал	27,455.2	17,500.0	-	17,500.0	-
9	Зар сурталчилгааны зардал	250.0	500.0	-	500.0	-
10	Бичиг хэрэг	1,734.6	1,500.0	196.5	1,303.5	13.1
11	Шуудан холбоо	1,902.6	2,700.0	-	2,700.0	-
12	Шатахуун	35,814.5	33,500.0	36,114.5	(2,614.5)	107.8
13	Шатах тослох материал	1,760.0	2,300.0	-	2,300.0	-
14	Сэлбэг материал, засвар	295,311.2	218,272.1	165,629.5	52,642.6	75.9
15	Сургалт	250.0	2,000.0	-	2,000.0	-
16	Татвар	67,217.9	70,000.0	52,566.4	17,433.6	75.1
17	Бусад зардал	56,210.0	31,661.0	117,825.5	(86,164.6)	372.1
18	Үйл ажиллагааны зардал	1,192,077.4	1,177,453.2	859,076.9	318,376.3	73.0
19	Г.Татварын өмнөх ашиг	54,833.3	-	(149,566.4)	149,566.4	-
20	Орлогын 1 төгрөгт ногдох зардал	1.1	1.0	0.8	0.2	82.6
21	Нийт авлага	2,178.8	-	-	-	-
22	Нийт өглөг	7,275.1	-	-	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,151.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 25,151.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Өр төлбөр, авлагыг нягтлан бодох бүртгэлд 25,151.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

Аудитаар нийт 17,976.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн дээрх 17,976.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа буюу зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,461.5 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1. Цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: И-баримтаарх худалдан авалтыг байгууллага тус бүрээр тулгахад харилцагч байгууллагуудаас 17,976.4 мянган төгрөгийн нэхэмжлэхийг цахим системд зөрүүтэй шивсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант хугацааны эцэст и-баримт илүү илгээсэн, нэхэмжилсэн байгууллагуудын төлбөр тооцоог хянан баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөг, авлагыг дутуу хаасан	1	25,151.8			1	25,151.8	1	25,151.8				
Дүн	1	25,151.8			1	25,151.8	1	25,151.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим төлбөрийн баримттай холбоотой	1	17,976.4					1	17,976.4				
Дүн	1	17,976.4					1	17,976.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагаатай холбоотой	1	123,022.7			1	123,022.7
Нийт дүн	1	123,022.7			1	123,022.7

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		